



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/37

Мяндаговь

「Газар эзэмших эрх дуусгавар болгох тухай」

Монгол Улсын Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэрт (Бага тойруу-1-102) байршилтай Дундговь аймгийн ерөнхий боловсролын Говийн ирээдүй цогцолбор сургууль (РД:9033769)-ийн 360 м² (0.03га) дотуур байрны газар нь хичээлийн байрны газартай давхардсан тул, 111600152 нэгж талбарын дугаартай газар эзэмших эрхийг дуусгавар болгосугай.

Хоёр. Дээрх байгууллагын газар эзэмших гэрээг цуцалж, гэрчилгээг хүчингүй болгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт үүрэг болгосугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулж аймгийн Засаг даргын 2012 оны А/328 дугаар захирамжийн Говийн ирээдүй цогцолбор сургуульд холбогдох 2 дахь хэсэг мөн газар эзэмших (0382945) тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210000